



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн үндсэн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д. Очирбат, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц. Төмөр-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оролцуулан, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д. Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б. ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТАЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. НАРАНГЭРЭЛ

- 133880663
9-t huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарын
2025 оны 07 дугаар сарын 22-ны/ний өдрийн
2023 дугаар тогтолцын хавсралт

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСАЛТ

Д/ Д	Хөрөнгийн нэр, төрөл, араал, улсын дугаар	КМ-ЫН ЗААЛТ	ҮЙЛДВЭРЛЭСЭН, АШИГЛАЛТАД ОРСОН ОН	БАЛАНСЫН ҮНЭ, ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ (ТӨГРӨГ)	ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ДООД ҮНЭ (ТӨГРӨГ)
1	Toyota hiace (Тоёото хайяс) маркийн 0314УНВ улсын дугаартай, TRH2260004247арлын дугаартай тусгай зориуулалтын (тургэн тусламжийн) автомашин,	309034	2008/2017	12,000,000.00	10,000,000.00
НИЙТ ДҮН					12,000,000.00 (арван хоёр сая)
					10,000,000.00 (арван сая)